

Бизнес Удирдлага докторантурын сургалтын хөтөлбөр

1. Хөтөлбөрийн танилцуулга:

Эдийн засаг, Менежментийн чиглэлээр магистрын зэрэгтэй, мэргэжлийн дагуу амжилттай ажиллаж, сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр тодорхой бүтээлтэй, онолын мэдлэг, чадвартай судлаачдыг элсүүлэн ахисан түвшний сургалтанд хамруулж, бизнес удирдлага, эдийн засгийн шинжлэх ухааны салбарт бодитой хувь нэмэр оруулах судлаач болгон төлөвшүүлэхэд оршино.

2. Хөтөлбөрийн зорилго:

Бизнесийн удирдлагын онол арга зүйн мэдлэгийг шинжлэх ухааны гүнзгий түвшинд эзэмшүүлж, бизнес, менежментийн асуудлыг онол, арга зүйд тулгуурлан судалгаа шинжилгээний ажил хийх ур чадварыг бүрэн эзэмшүүлж нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах судлаач эрдэмтдийг бэлтгэнэ.

3. Тус хөтөлбөрийг дүүргэснээр төгсөгчийн эзэмших ур чадвар:

Мэдлэг –

- Эдийн засаг, менежментийн орчин үеийн онол арга зүйн мэдлэгтэй болно.
- Эдийн засаг, менежментийн салбарын судалгаа шинжилгээ хийх аргачлалын талаарх мэдлэгийг олгоно.
- Эдийн засаг, менежментийн талаарх нарийвчлан сонгон авсан сэдвийн хүрээнд гүнзгийрүүлэх судлах, асуудал дэвшүүлэх, түүний талаар судалгаа хийх, судалгааны дүгнэлт дэвшүүлэх мэдлэгийг олгоно.

Чадвар –

- Докторант нь улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаа, түүний үйл явцад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хөгжлийн хандлага чиглэлийг урьдчилан томёолох чадвартай болно.
- Нийгэм эдийн засгийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, дүн шинжилгээ хийх ур чадвартай болно.
- Байгууллага, аж ахуйн нэгж, компани, корпорацийн болон салбар бүс нутгийн удирдлага, эдийн засгийн үйл ажиллагааг бодитой үнэлж, стратегийн хэтийн чиглэл, ойрын зорилтыг

оновчтой тодорхойлох чадвартай болно.

- Бизнесийн байгууллагын төлөвлөлт хийх төлөвлөгөө боловсруулах, оновчтой голч шийдвэр гаргах, удирдлагын уян хатан чанарыг дээдлэн эрхэмлэх, мэдээллийн техник хангамжийг чөлөөтэй ашиглах чадварыг эзэмшсэн байна.

4. Хөтөлбөрийн хүрээнд нийт цуглуулах кредит

Судлах хичээл	Доктор
Мэргэжлийн суурь хичээлүүд	12 кредит
Мэргэшүүлэх заавал судлах хичээл	12 кредит
Мэргэшүүлэх сонгон судлах хичээл	6 кредит
Судалгааны семинар	6кредит
Докторын ажил	24 кредит
Нийт	60кредит